

ГХС-ийн багш, ажилтан, төгсөгчдийн волейболын нөхөрсөг тэмцээн зохиогдов.

“Оюутан цагийн найз нөхөд, багш нартайгаа спортоор нэгдэж, нэг өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлэе” уриатай ШУТИС-ийн Гадаад хэлний сургуулийн Солонгос хэлний ангийн төгсөгчдийн нэрэмжит волейболын тэмцээн 2025 оны 11 дүгээр сарын 29-нд ШУТИС-ийн II байрны спорт зааланд болж өндөрлөв. Тэмцээнийг ГХС-ийн захирал Ц.Энхбаатар нээж ГХО-солонгос хэлний ангийн 1, 2-р курсийн оюутнууд дэвүүрт бүжиг, МХТС-ийн 2+2 хөтөлбөрийн ангийн 1, 2-р курсийн оюутнууд тэквандогийн үзүүлбэр тус тус үзүүлж ах эгч нартаа солонгосын соёлоос танилцуулав. Тус тэмцээнд нийт 7 баг бүртгүүлэн оролцсоноос Англи-Орос хэлний 2003 оны төгсөгчдийн баг алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, Хятад хэлний төгсөгчдийн баг мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, Солонгос хэлний багш нарын баг хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, Англи-Орос хэлний 2002, 2004 оны төгсөгчдийн холимог баг тусгай байранд орж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулав.

Энэ удаагийн тэмцээнд Англи-Солонгос хэлний 2008 оны төгсөгчдийн “Солонгос хэлний төгсөгчдийн баг” шинээр нэмэгдсэн ба Солонгос хэлний багш нар, Хятад хэлний төгсөгчид, Япон хэлний төгсөгчид, Англи хэлний багш нар, Англи-Орос хэлний 2002, 2004 оны төгсөгчид, Англи-Орос хэлний 2003 оны төгсөгчид тус тус баг бүрдүүлэн оролцлоо.

Жил ирэх тусам оролцогчдын тоо багасч байгаатай холбоотой 2 жил тутамд зохион байгуулж байхаар тохиролцсон ба. 2027 оны төгсөгчдийн тэмцээнийг Хятад хэлний ангийн хамт олон зохион байгуулахаар шилжин явах цомыг гардуулав. Тэмцээнд идэвхтэй оролцсон төгсөгчид, багш нартаа болон тэмцээн зохион байгуулахад мөнгөн дэмжлэг үзүүлсэн Солонгос хэлний ангийн төгсөгчиддөө гүнээ талархал илэрхийлж, ажил, амьдралд



нь өндрөөс өндөр амжилт хүсье.

*Баг тамирчид бэлэн жагссан.*



*Нээлтийн үйл ажиллагаа*





Англи хэлний багш нарын баг



Англи-Орос хэлний төгсөгчдийн баг Алтан медаль



Хятад хэлний төгсөгчдийн баг Мөнгөн медаль



Солонгос хэлний багш нарын баг Хүрэл медаль



Япон хэлний төгсөгчдийн баг



Англи-Орос хэлний төгсөгчид



Солонгос хэлний төгсөгчдийн баг



Дэвүүрт бүжиг



Таквандогийн үзүүлбэрээс

Мэдээ бэлдсэн АСТ-ийн профессор Н.Мэнд